

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2024 ОНЫ ЗДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

Төсвийн тухай хууль, дотоод аудитын дүрмийг баримтлан төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын зарцуулалт зэрэгт дотоод аудит явуулах, эрсдэлийн удирдлагаар ханган дүгнэлт зөвлөмж боловсруулах, үр дүнг тайлагнах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, дотоод аудитын үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчлах зэрэг ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллаа.

Дотоод аудит хийгдэх байгууллагуудын удирдамжыг аймгийн Засаг даргаар батлуулан 16 сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийлээ.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу Хангал сумын Хялганат тосгоны соёлын төв, Булган АЗЗА ТӨХК, хөгжимт жүжгийн театр зэрэг газруудад төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн.

Аймгийн ИТХ-ын зөвлөлийн хурал цахимаар хуралдан 2023 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн тухай тайлан хэлэлцүүлээ.



Аймгийн Засаг дарга хэлтэс агентлагуудын дарга нартай “2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г батлах арга хэмжээ зохион байгуулагдаж, албаны дарга Б.Баттулга оролцлоо.



Байгууллагын дарга “2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г батлуулсантай холбогдуулан төрийн захиргааны албан хаагчид төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан албаны даргаар батлууллаа.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах ажлын хүрээнд Дотоод аудитын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэхтэй холбоотой дараах сургалтуудыг 2024 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр цахимаар Удирдлага болон Админ эрхтэй албан хаагч нарт зориулсан сургалтад, 1 сарын 5-ны өдөр Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нарт зориулсан сургалтанд албаны албан хаагчид 100%-ийн ирцтэй хамрагдлаа.

2024 оны 03 сарын 21, 22-нд Орхон аймагт Хэнтий болон Булган аймгийн санхүүгийн хяналт дотоод аудитын албаны албан хаагчид “Нэгдсэн менежмент тогтолцоо” стандарт нэвтрүүлсэн сайн туршлага сургалт, санхүүгийн хяналт шалгалт дотоод аудит, шинээр нэвтрүүлж буй “Дотоод аудитын удирдлагын мэдээллийн систем”-ийн талаар санал солилцон, туршлага судаллаа.



Булган сумаас гаргасан уриалгаар бүх нийтийн цэвэрлэгээнд нэгдэж байгууллагын ойр орчмын хогийг цэвэрлэлээ.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД  
АУДИТЫН АЛБА